

ийм тоймтой зүйлийг баттай хэлэх боломж одоогоор алга юм. Гэвч хоёрдугаар бичээсийг бол Күл-тегин, Тоньюкук нарт зориулсан хөшөөний бичээсийг бичсэнээс өөр аялгуугаар бичсэн нь нилээд тодорхой байна. Хоёр бичээсийг хоёр өөр газар бичсэн байдлаас үзсэн ч, дотор өгүүлэгдэх зүйлийн агуулгаас үзсэн ч бичигдсэн аялгууны байдлаас үзсэн ч энэ нь тус тусдаа зүйл болох нь мэдэгдэж байна. Уг бичээсүүдийн дотор гарах өргөмж нэр, болон бусад нэр, цолын нэрээс үзвэл уг бичээсийг уйгарын хаант улсын үед хамруулан үзэх боломж олгохын гадна уг нэр цолтой хүмүүс тухайн үедээ ямар учир холбогдолтой болохыг гүйцэд нарийн судлахыг биднээс шаардаж, энэ чанараараа ч уг бичээсийн ач холбогдол тодорхойлогдох биз ээ.

ЖАРНЫ ТООЛОЛ

Л. ТЭРБИШ

Дэлхийн улс түмэн христосын буюу аргын, жарны буюу билгийн, хижрийн буюу дан ганц сарны тооллыг хэрэглэсээр иржээ. Христосын он тоолол нь христосын шашинт орнуудад үүсч дэлгэрсэн, нарны хөдөлгөөнд тохируулсан тоолол бөгөөд эдүгээ дэлхийн нийтийн он тоолол болсон байна. Хижрийн тоолол нь лалын шашинт орнуудад үүсч дэлгэрсэн, дан ганц сарны хөдөлгөөнд тохируулсан тоолол бөгөөд хижр 622 онд эхлэжээ. Харин буддын шашинт орнуудад дэлгэрсэн билгийн тоолол нь сар, нарны хөдөлгөөнийг давхар тооцож зохиодог тоолол юм.

Билгийн тооллыг зохиох онолын үндэслэл манай тооллын IX зууны үед Энэтхэг оронд тавигдаж, Төвдөөр дамжин улмаар Монголд нэвтэрчээ. Чингэхдээ Монголчууд нар, сар болон од, эрхсийн хөдөлгөөнийг монгол орны газрын хуваарьт тохируулан тооцох шинэ аргыг буй болгож, түүндээ тулгуурлан цаг тооллын бичгийг зохиосоор ирсэн түүхтэй Билгийн тооллыг аргын тоололтой тохируулахын тулд 3 жилд нэг удаа илүү сар гаргадаг. Өөрөөр хэлбэл билгийн 65 хагас сар буюу 32,5 сар тутамд нэг сарыг нэмж, түүнийгээ илүү сар гэх ба илүү сартай жилийг өндөр жил гэнэ.

- Билгийн тоололд жил, сар, өдрийг таван махбод хавсарсан арван хоёр амьтнаар нэрлэдэг. Язгуур таван махбод нь гал, шороо, төмөр, ус, мод ба арван хоёр амьтан нь хулгана, үхэр, бар, туулай, луу, могой, морь, хонь, бич, тахиа, нохой, гахай гэсэн дараалалтай байна.

Хулгана, бар, луу, морь, бич, нохойг эр; үхэр, туулай, могой, хонь, тахиа, гахайг эм жил гэдэг.

Мөн таван махбодод таван өнгө харгалзуулж 12 амьтнаар жилийг тоолох ёсон буй. Тэгэхдээ галд улаан, шороонд шар, төмөрд цагаан усанд хар, модонд хөх өнгийг харгалзуулна. Өнгө харгалзуулахдаа, эр

жилийг үндсэн өнгөөр, эм жилийг үндсэн өнгөнд»-гчин» дагавар залгаж нэрлэдэг. Жишээ нь гал туулай жилийг өнгө харгалзуулан нэрлэвэл улаагчин туулай болно.

Аргын 1027 оны гал туулай жилийг анхдугаар жарны эх болгон авчээ. Гал (улаагчин туулай эхлэлтэй таван махбод (өнгө) бүхий 12 жилийн бүтэн орчилогч жаран гэнэ. Тэгэхлээр жаран гал туулайгаар эхэлж гал бараар шувтарна.

Жарны жил тус бүр ёгт нэртэй байдаг. Тухайлбал төвдөөр «равжүн» (rab 9byung), санскритээр «брабхава» (bra bha ba), монголоор «машид гарсан» хэмээх нь гал туулай жилийн ёгт нэр (илт өгүүлэх) нэр юм. Жаранг ч мөн эхлэх жилээр нь «равжүн» гэж нэрлэж заншжээ.

Мөн жарнуудыг хүртэл ёгтлон нэрлэж байжээ. Тухайлбал, «машид гарсан тэргэл» (rab tsas) нь 15-р жарны ёгт нэр, машид гарсан ялагч» (rab rgyal) нь 16-р жарны ёгт нэр болно.

Түүхэн үйл явдлын он цагийг тогтоох, эх зохиолуудын төгсгөлийн үг дэх цаг хугацааг олох зэрэг арга, билгийн тооллын хамаарал, жил, сар, өдрийн ёгт нэрийг мэдэх чухал тул, жаран жилийн нэрийг төвд монголоор хадаж, арга, билгийн тооллыг өвөр хооронд нь шилжүүлэх хялбар дүрэм, ёгт нэрийн хамт хавсралт болгон хэвлүүлж байна.

Жаран эхлэх аргын жилүүд

I	1027	VII	1387	XIII	1747
II	1087	VIII	1447	XIV	1807
III	1147	IX	1507	XV	1867
IV	1207	X	1567	XVI	1927
V	1267	XI	1617	XVII	1987
VI	1327	XII	1687	XVIII	2047

Билгийн тооллын жилийг аргын тооллын онд шилжүүлэх арга

Тухайн жилийг жаран жилийн хүснэгтээс олж дугаарыг нь тэр жилд харгалзах жаран эхэлж буй аргын онд нэмээд нэгийг хасвал аргын он гарна.

Жишээ нь: XV жарны «Улбар шаргалт» хэмээх жил аргын хэдэн он болохыг дээрх дүрмээр бодъё.

Бодох нь: Жаран жилийн хүснэгтэд «Улбар шаргалт» хэмээх гал могой жил 51 гэсэн дугаартай бөгөөд XV жаран 1867 эхлэх тул $1867 + 51 - 1 = 1917$ он болно.

Аргын тооллын оныг билгийн тооллын жилд шилжүүлэх арга

Тухайн аргын оноос 1026-г хасч үлдэгдлийг 60-д хуваана. Гарсан ноогдвор дээр нэгийг нэмбэл жарны дугаар гарна. Үлдэгдэл нь билгийн тооллын хэддэх жил болохыг үзүүлнэ.

Жишээ нь: 1988 оныг билгийн тооллын жилд шилжүүлбэ.

Бодох нь: $1988 - 1026 = 962$. 962 -ыг 60 -д хуваавал 16 гарч, 2 үлдэнэ. $16 + 1 = 17$ нь жарны дугаар, жаран жилийн хүснэгтэд 2 гэсэн дугаартай жил бол шороон луу тул, аргын тооллын 1988 он нь XVII жарны шороон луу жил болж байна.

**Хаврын эхэн сарын шинийн нэгний арга билгийн
тохироо**

Аргын он тооллоор			Билгийн тоолол				
Оны	Сарын дугаар	өдөр	XVII жарны эхний 14-н жилийн нэр	Жил нэг бүрийн хоногийн тоо	Үүнээс	Тэргүүн сарын шинийн нэгэнд тохиолдох	
					384 хоногтой жилд аль сар нь илүү байх	Гаригийн нэр	Эр эм хосолсон таван өнгө бүхий 12 жил өдрийн нэр
1987	1	30	Улаагчин туулай	384	Хаврын тэргүүн сар илүү	Баасан	Шаргачин туулай
1988	2	18	Шар луу	355		Пүрэв	Харгачин туулай
1989	2	7	Шаргачин могой	384	Өвлийн тэргүүн сар илүү	Мягмар	Шар нохой
1990	2	26	Цагаан морь	354		Даваа	Хар нохой
1991	2	15	Цагаагчин хонь	354		Баасан	Улаан луу
1992	2	4	Хар бич	384	Зуны адаг сар илүү	Мягмар	Цагаан нохой
1993	2	22	Харгачин тахиа	354		Даваа	Хөх нохой
1994	2	11	Хөх нохой	354		Баасан	Шар луу
1995	1	31	Хөхөгчин гахай	384	Хаврын адаг сар илүү	Мягмар	Хар нохой
1996	2	19	Улаан хулгана	355		Даваа	Улаан нохой
1997	2	18	Улаагчин үхэр	384	Өвлийн дунд сар илүү	Бямба	Цагаагчин могой
1998	2	27	Шар барс	355		Баасан	Хөхөгчин могой
1999	2	17	Шаргачин туулай	354		Лхагва	Цагаан хулгана
2000	2	16	Цагаан луу	384	Намрын дунд сар илүү	Ням	Хөх морь

Өдрийн дугаарыг илт өгүүлэх нэрээр олох хүснэгт

Илт өгүүлэх нэр Дугаар	баясгалан	сайн	ялсан	хоосон	төгс
I	1	2	3	4	5
II	6	7	8	9	10
III	11	12	13	14	15
IV	16	17	18	19	20
V	21	22	23	24	25
VI	26	27	28	29	30

12 сарын илт өгүүлэх нэрийг олох хүснэгт

Сарууд	Жилээр нэрлэсэн нь	Төвд нэр	Илт өгүүлэх нэр
I	Барс	mchu	Их морь
II	Туулай	dpo	Харцага
III	Луу	nag	Тэргүүн дагуул
IV	Могой	sa ga	Эх тэнгэрт
V	Морь	snron	Хонгорцог
VI	Хонь	chu stod	Суулга
VII	Бич	gro bzhin	Яруу эгшигт
VIII	Тахиа	khums stod	Хөвүүн хушуут
IX	Нохой	tha skar	Шийдэм
X	Гахай	smin drug	Мичид
XI	Хулгана	mgo	Гөрөөсөн толгой
XII	Үхэр	rgyae	Найралт эх

Жаран жилийн илт өгүүлэх болон махбодьтой тохируулсан нэрийн хүснэгт

Жаран жилийн дугаар	Илт өгүүлэх нэр монгол, төвд	Махбодьтой тохируулсан нэр	Жаран жилийн дугаар	Илт өгүүлэх нэр монгол, төвд	Махбодьтой тохируулсан нэр
1.	Машид гарсан rab byung	гал туулай	21.	Хамгийг номхотгогч tham cad dul	гал гахай
2.	Тийн гарсан nam byung	шороон луу	22.	Хотлыг баригч kun dzin	шороон хулгана
3.	Цагаан dkar po	шороон могой	23.	Харшлалт gal ba	шороон үхэр
4.	Машид согтонги rab myos	төмөр морь	24.	Тийн урвагч nam gyur	төмөр барс
5.	Төрөлхтөний эзэн skyes bdag	төмөр хонь	25.	Илжиг bong bu	төмөр туулай
6.	Муу биет anggi ra	усан бич	26.	Баясгалант dga ba	усан луу
7.	Цогт нүүрт dpal gdong	усан тахиа	27.	Тийн ялгуусан nam rgyal	усан могой
8.	Бодь dngos po	модон нохой	28.	Ялгуусан rgyal pa	модон морь
9.	Насан төгөлдөр na tsod ldan	модон гахай	29.	Галзууруулагч smyos byed	модон хонь
10.	Баригч dzin byed	гал хулгана	30.	Нүүр муут gbong ngan	гал бич

1	2	3	4	5	6
11.	Эрхт баялаг dbang rhyung	гал үхэр	31.	Алтан унжлагат gser 'phyang	гал тахиа
12.	Олон үрт Bru mang	шороон бар	32.	Тийн унжлагат nam rhyang	шороон нохой
13.	Согтуу төгөлдөр myos ldan	шороон туулай	33.	урвуулагч sgyur byed	шороон гахай
14.	Тийн дарагч nam gnon	төмөр луу	34.	хотол төгс kun ldan	төмөр хулгана
15.	Сүргийн манлай khyu mchog	төмөр могой	35.	Цөөвөр Phar ba	төмөр үхэр
16.	Элдэв Sna tsogs	усан морь	36.	Буян үйлдэгч dye byed	усан бар
17.	Наран nyi ma	усан хонь	37.	үзэсгэлэн үйлдэгч mdzes byed	усан туулай
18.	Наран гэтэлгэгч nyi sgröl byed	модон бич	38.	хилэнт эх khro mo	модон луу
19.	Газар тэтгэгч sa skyong	модон тахиа	39.	элдэв эрдэнэт sna tsogs dbyig	модон могой
20.	Барагдашгүй mi zad	гал нохой	40.	сүрээр дарагч zil gnon	гал морь
41.	Бич sgru u	гал хонь	51.	улбар шаргалт dmar ser can	гал могой
42.	Гадас Phur bu	шороон бич	52.	цагийн элчин duskyi pho nya	шороон морь
43.	Амирлангуй Zhi ba	шороон тахиа	53.	тус бүтээгч don grub	шороон хонь
44.	Ерөнхий Thun mong	төмөр нохой	54.	догшин drag po	төмөр бич
45.	Харшлагч Gal byed	төмөр гахай	55.	муу окуут blo ngan	төмөр тахиа
46.	Огоот баригч Yongs dzin	усан хулгана	56.	их хэнгэрэг nga chen	усан нохой
47.	Сэрэмжгүй Bad med	усан үхэр	57.	цусаар бөөлжигч khrag bskyug	усан гахай
48.	Хотол баясгалант Kun dga	модон барс	58.	улаан нүдэн mig dmar	модон хулгана
49.	Мангас Srin po	модон туулай	59.	хилэнт khro bo	модон үхэр
50.	Гал me	гал луу	60.	барагдагч zad pa	гал барс